

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

№ 19/58

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дах заалт, 76.2 дах хэсэг, 80 дугаар зүйлийн 80.4, 80.5 дах хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1, “ЛэндМН ББСБ” ХК-ын дүрмийн 9.6.4, 9.6.20 дах заалт, 9.10, 20.5, 20.6 дэх хэсгийг болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1.ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан Анд Системс ХХК-аас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.

Санхүүжилтын төрөл	Зээл
Зээлийн хугацаа	24 сар хүртэл хугацаатай
Зээлийн хэмжээ	Төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл дүн 12,000,000,000 (арван хоёр тэрбум) төгрөгөөс хэтрэхгүй
Зээлийн хүү	Анд Системс ХХК-ийн татсан эх үүсвэрийн өртөг дээр холбогдох татвар нэмж тооцсон хувь
Зээлийн эргэн төлөлт	Анд Системс ХХК-ийн санхүүжилтын эх үүсвэрийн эргэн төлөх нөхцөлийн дагуу
Зээлийн хүү төлөх нөхцөл	Анд Системс ХХК-ийн татсан эх үүсвэрийн хүү төлөх нөхцөлийн дагуу
Барьцаа	Барьцаагүй

2.Зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.

3.Анд Системс ХХК-тай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

4.Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

...../С.БОРГИЛ//С.ЭНХ-АМГАЛАН/
...../Ж.ЖАРГАЛСҮРЭН//Ч.НОМИН/
...../Н.ЦЭВЭГМИД/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД
ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1116267206

Улаанбаатар хот



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

№ 19/60

Улаанбаатар хот

Хэлцэл хийх эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.3, 80.4 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.19, 9.10, 9.11 дэх заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Гадаад валютын ханшийн эрсдлийг удирдах зорилгоор Капитрон Банк (“Банк”)-нд 1,600,000 (нэг сая зургаан зуун мянга) хүртэлх хэмжээний АНУ-ын долларыг хугацаатай хадгаламжийн данс нээж, байршуулах, уг хадгаламжийг барьцаалан, энэхүү тогтоолын 1 дүгээр Хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд байршуулсан хадгаламжийн дүнгийн 80 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн зээл авах, Зээлийн болон холбогдох бусад гэрээ, хэлцэл байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт зааснаар Капитрон Банктай байгуулсан Зээлийн гэрээний нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

...../Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

...../О.БОЛДБААТАР/

...../С.БОРГИЛ/


...../В.БАЯРСАЙХАН/

...../Н.ЦЭВЭГМИД/

...../С.ЭНХ-АМГАЛАН/

...../Ж.ЖАРГАЛСҮРЭН/

...../Ч.НОМИН/



**КАПИТРОН БАНКТАЙ ХИЙХ
ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛЖ ЗЭЭЛ АВАХ ХЭЛЦЭЛИЙН НӨХЦӨЛ**

	Нөхцөл
Хадгаламжийн хэмжээ	1,600,000 хүртэл АНУ-ын доллар
Хугацаа	6 – 12 сар
Хадгаламжийн валют	АНУ-ын доллар
Зээлийн валют	Төгрөг
Зээлийн дүн	[Байршуулсан хадгаламжийн үнийн дүн х 85% х Зээлд хөрвүүлэх ханш]
Зээлийн хүү (жил, дээд хувь)	Хадгаламжийн хүү + 7.5%
Нэмэлт барьцаа	Байхгүй
Нэмэлт барьцааны дүн	Байхгүй
Төгрөгийн зээлийн хэмжээ тооцоход баримтлах ханш	Банктай тохирсон ханшаар

Handwritten signature